



MONGOLIAN CASHMERE

**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 24-ний өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулагдав. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр, Б.Нандин-Эрдэнэ, ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг, Ц.Баатарсайхан, Тэргүүн Дэд захирал О.Болорбат нар оролцов.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Та бүхний өглөөний амар амгаланг айлтгая. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн боллоо. Энэ жил бид онцгой нөхцөл байдалд хурлаа зохион байгуулах асуудалтай тулгарсан. Хурлыг цахим хэлбэрээр шууд дамжуулалтаар та бүхэнд хүргэхээр болж байгаа. Шууд дамжуулалтыг та бүхэнд хүргэж байгаа компанидаа бас талархаж байгаагаа хэлье. Livestream компанитай бид нар хамтарч ажиллаж байгаа. Хурал өрнөж байгаа талбар маань Outlet дэлгүүр байгаа. Хурлаа албан ёсоор эхлүүлэхээс өмнө хурлыг албажуулдаг нэг чухал зүйл байдаг. Тооллогын комиссын дарга Н.Сайнзулыг ирцийн мэдээллийг өгнө үү хэмээн хүсэж байна.

ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Н.Сайнзул: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Говь ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг мэдээлье. 2020 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөр тасалбар болгон хувьцаа эзэмшигчдийн бүртгэлээр Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 ширхэг байсан. 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцогчдыг 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс 23-ны өдөр хүртэл бүртгэсэн бөгөөд өнөөдрийн хуралд 690,229,999 ширхэг саналын эрхтэй нийт 84 хувьцаа эзэмшигч оролцож хурлын ирц 88.48 хувь болсноор компанийн тухай хуулийн 69.1-д заасны дагуу хурлын ирц бүрдсэнийг мэдэгдэж байна.

ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Тооллогын комиссын дарга Н.Сайнзулдаа баярлалаа. Ирц хуулийн шаардлагыг хангаж байгаа учир хурлаа албан ёсоор нээж байгааг мэдэгдэж байна. Та бүхэн магадгүй гайхаж байгаа байх. Үүссэн нөхцөл байдлаас үүдэн бүгд зай барих маск зүүх гэсэн асуудлуудыг хүн болгон тус бүрдээ хэрэгжүүлж байгаа. Гэхдээ дууны чанарыг сайн байлгах үүднээс энд ярьж байгаа хүмүүс ярих үедээ маскаа авч

байгаа гэдгийг та бүхэнд танилцуулах нь зөв байх. Хуралтай холбоотой дараах 2 асуудлыг танилцуулъя. Нэгдүгээрт би хурлын ирцийг та бүхэнд танилцуулах шаардлагатай байдаг. Хурлын дэг дээр мэдээж эхний ээлжид ирцийн мэдээллийг танилцуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг сая би нээсэн. Тооллогын комисс томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулна. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу илтгэлүүдийг та бүхэнд хүргэнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт хариултыг бид урьдчилсан байдлаар бүртгэл хийж байх явцдаа та бүхнээс цуглуулж авсан байгаа. Энэ ирсэн асуултуудад бид тус бүрд нь хариулт өгнө. Санал хураалтын үеэр нэмж асуултууд орж ирвэл бид асуулт хариултын хэсгийг өргөжүүлээд явна гэдгийг хэлэхэд таатай байна. Санал хураалт явагдана. Тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгээд үр дүнгээ танилцуулаад тогтоолын төслийг бидэнд танилцуулна. Үүнээс гарах шийдвэрүүдийг тогтоол болгож та бүхэнд танилцуулаад хурал албан ёсоор дуусах юм. Хурлаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд тухайлан танилцуулъя. Бид 6 асуудлыг та бүхэнтэй хэлэлцэж шийдвэр гаргах хэрэгтэй байгаа. Нэгдүгээрт компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах. Манай тэргүүн дэд захирал Болорбат та бүхэнд танилцуулна. Хоёрдугаарт ТУЗ-ийн зүгээс 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулж баталгаажуулна. Гуравдугаарт компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагатай байгаа энэ асуудлыг та бүхэнд хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулна. Дараа нь 2018 оны ногдол ашиг тараалтын тайлан болон 2019 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг та бүхэнд танилцуулна. Тавдугаарт ТУЗ-ийн зүгээс 2019 онд хийсэн ажлаа тайлагнана. Зургаадугаарт ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг та бүхэнд хүргэж санал хураалтаар шийдвэр гарна. Одоо ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа-г индэр дээр урьж байна. Тооллогын комисс томилсон тухай тогтоолыг танилцуулна уу.

ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол улс, Говь ХК, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тогтоол, 2020 оны 3 сарын 14-ний өдөр тогтоол дугаар 8, Улаанбаатар хот, Тооллогын комиссыг томилох тухай. Говь ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахтай холбогдон, тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2020 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга:	Н.Сайнзул – Дотоод аудитын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Цэцэгбадам – Санхүү бүртгэлийн албаны дарга
Гишүүд:	Т.Мөнхзул – Ахлах аудитор
	Б.Уянга– Хөдөлмөрийн харилцаа хариуцсан албаны дарга
	С.Билэгжаргал – Борлуулалт бүртгэлийн албаны дарга

Г.Ганзаяа – Ахлах нягтлан бодогч
Д.Энхболор – Санхүүгийн шинжээч

Хоёр. Тооллогын комисс (Н.Сайнзул)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Саналын хуудсыг хайрцгаар мөн цахим хэлбэрээр авах;
6. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
7. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах.

Баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Нарантуяадаа баярлалаа. Дараагийн асуудалдаа орьё. Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тэргүүн дэд захирал О.Болорбат танилцуулна. О.Болорбат захирлыг урьж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

1. Компанийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах

Тэргүүн Дэд захирал О.Болорбат танилцуулав.

О.Болорбат: Та бүхний энэ өдрийн мэндийг ирье. Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг та бүхэнд танилцуулъя. Говь ХК санхүүгийн нөөц, хүний нөөц, үйлдвэрийн нөөц, оюуны нөөц, байгалийн нөөц, нийгэм харилцааны нөөцөд үндэслэн монголчуудын уламжлалт аж ахуй болох ямааны ноолуураас гаргаж авсан эцсийн бэлэн бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд хүргэх эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. 2019 он Говь ХК-ийн хувьд монголын дотоодын зах зээл болон олон улсын зах зээл дээр бизнесийнхээ цар хүрээг өргөжүүлэх, үйлдвэрлэлийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлсэн түүхэн шийдвэр гаргасан жил байлаа. Говь ХК нь Гоёо ХХК-г өөрт нэгтгэснээрээ үйлдвэрлэлийн бүтээмж өсөж, ажилчдын чадамж дээшилсэн мөн нийт харилцагчдын дата баазыг нэгтгэж үйлчилгээний чанар болон хурдыг сайжруулсан. Хамгийн гол нь зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж харилцан бие биеэсээ суралцах боломжийг бүрдүүлээд ажиллаж байна. 2019 онд Говь ХК-ийн нийт борлуулалтын орлого 210 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 21 хувийн өсөлттэй. Дотоод борлуулалт 135 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 20 хувийн өсөлттэй. Гадаад борлуулалт 75 тэрбум төгрөгт хүрч 22 хувийн өсөлттэй, хөрөнгө оруулалт 60 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 105 хувийн өсөлттэй. Төсөвт нийт 34.4 тэрбум төгрөгийн татвар төлж, ажилтнуудын тоо 499 хүнээр нэмэгдсэн байна. Сүлжмэл бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 972 мянган ширхэгт хүрч 22 хувийн өсөлт гаргасан байна. 2020-2024 оны хооронд Говь ХК-ийн хувьд Гоёо ХХК-тай нэгдсэн нэгдлийн бүтээмжийг өсгөх, илүү харилцан уялдаатай ажиллах арга замуудыг

эрэлхийлэн ажиллаж байна. 2007 онд хувьчлагдсанаас хойш нийт 147 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг бид үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөхөд мөн дэд бүтцийг сайжруулахад зарцуулаад байна. 2019 оны хувьд 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум нь тоног төхөөрөмж, барилга байгууламж болон бусад хөрөнгө оруулалтад зарцуулагдсан бөгөөд нэгтгэлийн хөрөнгө оруулалтад 37 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт зарцуулагдсан байна. 2019 онд хийгдсэн дээрх хөрөнгө оруулалтуудын 21 тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 1.4 тэрбум төгрөгийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 671 сая төгрөгийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна. 2019 онд дотоод борлуулалт 135 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 20 хувийн өсөлттэй. Энэ дүн нь Монгол улсын ноолуурын бэлэн бүтээгдэхүүний борлуулалтад 83 хувийг эзэлж байна. Нийт дотоодын худалдан авагчдыг харьяаллаар салгаж авч үзвэл 51 хувийг Монгол худалдан авагчид, 49 хувийг гадаадын жуулчид хийсэн байна. Говь брэнд маань Монгол хэрэглэгчдийн тэргүүн сонголт гаднын жуулчид төлөөлөгчдийн өмнө Монголын нэрийн хуудас болсон дэлгүүр байж нийт 6 салбар дэлгүүрээр буюу үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүр, Галлериа Улаанбаатар салбар дэлгүүр, Смарт салбар дэлгүүр, Outlet дэлгүүр, Чингис Хаан ОУНОБ дэлгүүр, Дархан салбар дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд бараа бүтээгдэхүүнээ хүргэж байна. Говь ХК 2019 оны эцсийн байдлаар 12 улсын 34 хотод 53 франчайз дэлгүүр, 3 охин компанийн хамт үйл ажиллагаа явуулж байна. 2019 онд гадаад борлуулалт 75 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 22 хувийн өсөлттэй байгаа ба Монгол улсын нийт эцсийн бүтээгдэхүүний экспортын 74.2 хувийг эзэлж байна. 2019 оны 1 сард Хонконгд, 2-р сард Сан Францискод, 6 сард ОХУ-ын Тыва хотод салбар дэлгүүрүүдийг франчайз эрхтэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Мөн АНУ-ын Лос Анжелес хотод охин компанийг байгуулж үйл ажиллагаа явуулж байна. Мөн 2019 онд Говь ХК олон улсын хэрэглэгчдэдээ улам ойртож гэрт нь бараа бүтээгдэхүүн хүргэж өгөх зорилготойгоор Монгол улсдаа хамгийн анхны онлайн зах зээл дээр илүү анхаарал төвлөрүүлж ажиллаж байна. Одоогийн байдлаар АНУ, ХБНГУ, БНХАУ-д төвлөрсөн онлайн платформ үйл ажиллагаа, маркетингийн дэд бүтэц, боловсон хүчний хамтаар онлайн борлуулалтыг явуулж байна. ХБНГУ дахь салбар зөвхөн Герман улс төдийгүй Европын холбооны бусад нийт 28 оронд бараа бүтээгдэхүүний борлуулалт маркетингийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна. Тухайн зах зээлүүд болоод улам олон зах зээл дээр өөрийн шууд онлайн худалдаагаар дамжуулан тухайн орны хэрэглэгчийн хэл, зах соёл, хэрэглээний онцлогт тохируулан бүтээгдэхүүний үйлчилгээ брэндээ таниулж борлуулалтаа нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Европын холбооны зах зээлд төвлөрсөн gobicashmere.com веб сайт 2019 оны 7 дугаар сараас онлайн маркетинг сурталчилгаагаа идэвхжүүлснээр өмнөх үеийн мөн үеэс борлуулалтаа 9 дахин өсгөж 2.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. Тус сайтаар өдөр бүр 7,800 гаруй хандалт орж ирж нийт 232 загвараар 10,014 ширхэг бүтээгдэхүүн борлуулсан байна. АНУ-д us.gobicashmere.com веб сайтын онлайн үйл ажиллагаа 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр эхэлж, нийт 157 загвараар 5,180 ширхэг бүтээгдэхүүн борлуулж, 1.3 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Уг сайтар өдөр бүр дунджаар 4,800 гаруй хүн хандаж орж ирсэн. БНХАУ-ын зах зээлийн хувьд gobicashmere.taobao.com 2019 оны 3-р улирлаас эхлэн ажиллуулснаар өнгөрсөн оноос борлуулалт 3 дахин өсөж 1 тэрбум төгрөг хүрсэн байна. Тус сайтаар өдөрт 3,500 гаруй хүн хандан үйлчлүүлсэн бөгөөд нийт 178 загвараар 2,449 ширхэг бүтээгдэхүүн борлуулсан байна. 2019 онд Говь

ХК-ийн Монгол улсын эдийн засаг нийгэмд оруулсан хувь нэмрийг үнэлж Монгол улсын Засгийн газар, Худалдаа аж үйлдвэрийн танхимаас зохион байгуулдаг “Топ 100 аж ахуйн нэгж” шалгаруулах ёслолын арга хэмжээнд 18 дугаар байранд шалгаруулсан байна. Говь ХК мөн 2019 онд “Монголын Хаан ширхэгт тохирлын гэрчилгээ”-г хүлээж авсан байна. Та бүхэнд 2019 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

2. ТУЗ-өөс компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Болорбат захиралдаа баярлалаа. Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үргэлжилж байна. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя. ТУЗ нь компанийн тухай хууль, ТУЗ-ийн дүрмийг мөрдлөг болгон ажиллаж, үндсэн ТУЗ-ийн хурлаар үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталгаажуулсан байгаа. Тус тайланд гарч ирж буй гол гол санаануудыг та бүхэнд танилцуулъя.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах, хянах, чиглүүлэх сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ. Манай гүйцэтгэх удирдлагын баг ТУЗ-ийн өгч байгаа зөвлөмж, бодлого, хяналтын дагуу төлөвлөгөөт зорилтуудыг сайн хийж гүйцэтгэлээ. Гол үр дүнгээс та бүхэнтэй хуваалцвал, Говь ХК 2019 онд 210 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 93 хувь, цэвэр ашиг 2.4 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 26 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2019 онд 75 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 101 хувь, дотоод борлуулалт 135 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 90 хувьд хүрчээ. Мөн тайлант жилд 411 тонн түүхий эд бэлтгэж, нийт 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн та бүхэн тэргүүн дэд захирлын тайлангаас сонссон байх. Нийт 60 тэрбумаас 37 тэрбум нь Гоёо ХХК-ийг худалдаж авахад бид зарцуулсан. Энэ худалдаж авсан шийдвэр гаргалт нь өөрөө стратегийн өндөр ач холбогдолтой, ялангуяа олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдөх өрсөлдөхүйц том компани болохын тулд хүчээ нэгтгэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх боломж олгосон гэж бидний зүгээс ойлгож байгаа. Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үргэлжилж байна. Хэлэлцэх асуудлын 3-руу оръё. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах талаар асуудлыг хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулна. Таныг индэр дээр урьж байна.

3. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлын талаар танилцуулах

Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр танилцуулав.

Хуулийн хэлтсийн дарга Ц.Цасчихэр: Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Компанийн ТУЗ-өөс компанийн дүрмийг өөрчлөхөөр оруулсан 2 саналыг та бүхэнд танилцуулъя. Нэгдүгээрт компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд компанийн дүрэмд заавал тусгах зүйлсийг хуульчилсан байдаг. Компанийн тухай хуулийн 16.2.2 Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг заавал тусгана гэж заасан байгаа. Манай компанийн дүрмийн 3.1-т Компанийн гаргасан хувьцааны тоог тусгасан байгаа. Өөрчлөлтөөр гаргасан хувьцааны тоог оруулж бусад хувьцааны тоо болон тэдгээрийн төрөл нэрлэсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй ийм утга орж байгаа юм. мөн мэдээллийн шинж чанартай хүргэхэд компани эргүүлж худалдаж авсан халаасны хувьцаа байхгүй байгаа. Хоёрдугаар асуудал бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн асуудал байгаа, компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоохоор хуульчилсныг компанийн өрийн хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүнийг тоог хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. ТУЗ-өөс энэхүү асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж болно хэмээн оруулж өөрчилсөн байна. Энэхүү өөрчлөлтүүд нь компанийн үйл ажиллагааг хуульд нийцүүлж, компанийн засаглалыг сайжруулах ач холбогдолтой учир та бүхэн дэмжиж саналаа өгөөрэй гэж хүсэж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Ц.Цасчихэр даргад баярлалаа. Одоо хэлэлцэх асуудал 4 буюу хувьцааны үнэ, 2018 оны ногдол ашиг тараалтын тайланг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Нарантуяа танилцуулна.

4.3 Хувьцааны үнэ, 2018 оны ногдол ашиг тараалтын тайланг танилцуулах *ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа танилцуулав.*

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа: Та бүхэнд хувьцааны үнэ, ногдол ашиг тараалтын талаарх тайланг танилцуулъя. Хувьцааны арилжааны хувьд 2019 оны 12 сарын 31-ний байдлаар хувьцааны хаалтын үнэ 270 төгрөг, хамгийн их үнэ 354 төгрөг, хамгийн бага үнэ 251 төгрөг, дундаж үнэ 291 төгрөг байсан байна. Арилжаалагдсан тоо ширхгийн хувьд авч үзвэл хамгийн ихдээ өдөрт 261,527 ширхэг, хамгийн багадаа өдөрт 1,068 ширхэг, дунджаар өдөрт 31,146 ширхэг, нийт өдөрт 7,848,937 ширхэг арилжаалагдсан байна. Арилжааны үнийн дүнг танилцуулбал хамгийн ихдээ өдөрт 87,630,808 төгрөг, хамгийн багадаа өдөрт 284,711 төгрөг, дунджаар 9,398,943 төгрөг, нийт 2,368,533,634, төгрөг арилжаалагдсан байна. 2019 оны 12 сарын 31-ний байдлаар компанийн зах зээлийн үнэлгээ 210,630,375,000 төгрөг байсан байна. 2018 оны ногдол ашиг тараалтын тайланг танилцуулахад, компани 2018 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6.8 төгрөгийг зарласан байгаа. Ногдол ашгийг 2019 оны 4 сарын 25-ны өдрөөс эхлэн тарааж эхэлсэн бөгөөд Говь ХК-ийн байран дээр кассаас бэлэн мөнгөөр болон хувьцаа эзэмшигчдийн хүсэлтээр дансаар тараасан. 2019 оны 12 сарын 27-ны өдөх үлдэгдэл тооцоон ҮЦТХТөв-тэй гэрээ хийн тараан дуусгасан. 2019 оны хувьд ТУЗ-ийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.

5. ТУЗ-ийн 2019 оны ажлын тайланг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Б.Нарантуяадаа баярлалаа. Сая манай ханшны мэдээлэл, ногдол ашиг тараалтын байдлын талаарх мэдээлэл хүрлээ. Одоо манай хурлын нэлээн том чухал хэсэг байдаг. ТУЗ-ийн гишүүд тайлант хугацаанд хийсэн ажлууд, ажлын үр дүн ямар байгаа тухай, бид өөрсдийгөө юу гэж дүгнэж байгаа, хөндлөнгөөр үнэлгээ хийлгээд манай үнэлгээ хэрхэн гарсан тухай чухал тайланг та бүхэнд танилцуулъя. Та бүхний эрхийг бид хэрэгжүүлж байгаа учир та бүхэнд энэ мэдээлэл нэлээн чухал байх болов уу гэж бодож байна. ТУЗ 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа. 4 ердийн гишүүн, 5 хараат бус гишүүн. Мэргэжлийн хүмүүс ажиллаж байгаа үүнийг дагаад гүйцэтгэл нэлээн муугүй байдаг. Бид хамтын ажиллагаа буюу Говь ХК-ийг удирдахдаа, хянах, чиглүүлэх үүргээ хэрэгжүүлэхдээ хамтын удирдлагын зарчим буюу засаглалын дүрэм журам, бичиг баримтуудыг нэлээн тодорхой болгосон. Бүх шийдвэрүүд, үйл ажиллагаанууд тодорхой дүрэм журмын дагуу хэрэгждэг гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Ер нь ТУЗ-ийн үйл ажиллагаа ямархуу зарчим, тогтолцоогоор явдгийг та бүхэнд танилцуулахад, хувьцаа эзэмшигчдийн хурлаас бид эрхээ авдаг, ТУЗ бүрддэг. ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын багыг чиглүүлэх, хянахдаа 3 хороогоор дамжуулж бид үйл ажиллагаагаа явуулж байгаа. Мэдээж ТУЗ-ийн хурал гэдэг нь чухал шийдвэр гаргадаг тулах цэг нь байдаг. Гэхдээ хажуугаар нь эрсдэл удирдлагын чиглэлээр тусгай хороогоор урьдчилсан байдлаар хяналтаа сайн тавихыг хичээж байгаа. Цалин урамшууллын хороо болон нэр дэвшүүлэх хороо жилд 2 удаа хуралддаг. Засаглалын бүтцийн нэгжүүд үндсэндээ хамтын удирдлагын зарчим, бүх зүйлийг тодорхой ойлгомжтой байлгах үүднээс хорооны хурлууд чиглэгддэг. Та бүхэнд одоо ажлаа танилцуулаад тайлангийн төгсгөлд өөрийн үнэлгээг эрсдэл аудитын хороотой хамтарч хийсэн. Анх удаа бид салхи хагалах үүднээс хөндлөнгийн оролцогчдыг оруулж үнэлгээ хийсэн байгаа. ТУЗ энэ жил 14 удаа хуралдсан, ээлжит хурал 5, ээлжит бус хурал 9. Хурлын үр дүнгээс танилцуулбал, үйл ажиллагаа өргөжүүлэх, хөрөнгө оруулалтын хүрээнд 4 тогтоол, компанийн дотоод үйл ажиллагаатай холбоотой 8 тогтоол, санхүүжилттэй холбоотой 6 тогтоол, хүний нөөцтэй холбоотой 8 тогтоолыг тус тус ТУЗ-ийн хэмжээнд баталсан байна. Эхний ээлжид эрсдэл аудитын хорооны тайланг та бүхэнд танилцуулъя. Эрсдэл аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Б.Нандин-Эрдэнэ, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хулан, ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа нар ажилласан. Нийт 3 удаа хуралдаж, 17 асуудлыг хэлэлцэж, 3 тогтоолыг баталсан. Мөн хороо чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 7 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан байна. Онцлох ажлыг танилцуулбал, Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд санхүүгийн тайлан, НББ-ийн талаар хараат бус аудиторын дүгнэлт зөвлөмжтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан бөгөөд эрсдэлийн удирдлагын баг болон дотоод аудитын хэлтсийн ажлын гүйцэтгэл, хагас жилийн ажлын тайлантай цаг тухай бүрд танилцаж чиглүүлэн ажиллав. Мөн эрсдэлийн удирдлагын багийг бүтцийг шинэчлэн баталж дотоод аудитын хэлтсийн даргын сонгон шалгаруулалтыг явуулж, дотоод аудитын хэлтсийн 2020 оны үйл ажиллагаа болон цалингийн төсвийг баталсан байна.

Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Баяр ажилласан. ТУЗ-ийн гишүүн миний бие болон ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Баатарсайхан захирал энэ хороонд харьяалагдаг. Бид өнгөрсөн жил 2 удаа хуралдсан. 9 асуудлыг хэлэлцэж 3 тогтоол баталсан. Хороо чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 4 төрлийн санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан. Онцлох ажлыг дурдвал эрх бүхий албан тушаалтнуудын талаар баримтлах бодлогыг шинэчиллээ, цаг хугацаа биднийг байнгын өөрчлөлттэй байлгаж байгаа учир бодлогын шинэчлэлтийг оруулсан байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн шалгуур үзүүлэлтүүдийг шинэчилсэн байгаа. ТУЗ-ийн өөрийн үнэлгээний асуулгыг бид нар өөрчилсөн. Бид бас ажлаа дүгнэдэг. Дотроо нөөц бололцоо юу байгаа талаар, аль чиглэлээр сайн ажиллаад аль чиглэлээр алдаа өгч байгаа талд өөрийн үнэлгээг тасралтгүй хийж ирсэн. Энэ асуулгууд одоо арай өөр өнгө аястай болсон байгаа. ТУЗ өөрийн үйл ажиллагааг сайжруулах зүйлс энэ асуулгаас гарах болов уу гэж бодож байна. Түүнчлэн удирдлагын багийн хагас жилийн тайланг Баатарсайхан захирал бидэнд танилцуулдаг. Бид нар танилцдаг. Манай гүйцэтгэх удирдлагын багийн ажил ямар байгаа талаар тасралтгүй мэдээлэлтэй ажилладаг. Үүн дээр зөвлөмж боловсруулах ийм чиглэлээр хамтарч ажиллаж байгаа. Өөрийн үнэлгээг хийсэн. Хороодын хамтын ажиллагааг сайжруулах асуудалтай тулгарсан өнгөрсөн жил бүхэлдээ хамтын ажиллагааны чиглэлд анхаарал хандуулсан байгаа. Төгсгөлд нь хэлэхэд нэр дэвшүүлэх хорооноос чухал ажлыг хийж гүйцэтгэсэн өөрийн үнэлгээний асуулга байдаг, ТУЗ-ийн гишүүд өөрсдийн ажлыг үнэлдэг байсан бол энэ удаа дотоод аудитын газартай хамтран ажиллаад манай засаглалын үнэлгээ ямархуу түвшинд явж байгааг үнэлүүлсэн. Та бүхэн анзаарч байгаа бол манай тайлан дээр 93, 92 гараад байдаг байсан үзүүлэлт маань 86 руу бууж ирсэн. Энийг бол би нэлээн сайн үзүүлэлт гэж харж байгаа. Учир нь хөндлөнгийн нүдээр бид нарыг харахад ямар байна цаашаа өсөж дэвжих өөрсдөө олж харж чадахгүй байгаа асуудлуудаа эргэж харах боломжууд олгосон өвөрмөц ажил хийгдлээ.

Цалин урамшууллын хорооны бүтэц, ажлын тайланг та бүхэнд танилцуулъя. Цалин урамшууллын хорооны даргаар миний бие ажилладаг. Манай хороонд ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ, ТУЗ-ийн ердийн гишүүн Ж.Оюунчимэг нар ажилладаг. Бид өнгөрсөн жил 2 удаа хуралдсан. Нийт 6 асуудлыг хэлэлцэж, 3 тогтоолыг баталсан. Хороо чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч, хяналт тавьж ажилласан. Онцлох ажлыг дурдвал компанийн соёлын болон сэтгэл ханамжийн судалгаа тасралтгүй байнга хийгддэг болсон үүний үр дүнг бид нэлээн хардаг. Манай компанийн үнэт зүйлст бүтээлч сэтгэлгээтэй ажилтан маань өөрөө байдаг. Тэгэхээр ажилтны сэтгэл ханамжийн асуудал бол ТУЗ-ийн түвшинд яригддаг байгаа. Энэ асуудал дээр бид гүйцэтгэх удирдлагын багтай хамтарч ажилладаг. Гарсан үр дүн дээр бодлогын чиглэлийн өөрчлөлтүүдийг гаргаж ирэх нарийн үйл ажиллагаануудыг хийлээ. Хороо чиг үүргийнхээ дагуу өнгөрсөн оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, ирэх жилийн цалин урамшууллын төсвийг баталгаажуулаад явдаг байгаа. Ийм үүрэгтэйгээр бид өнгөрсөн жил ажилласан байна. Хороодын үйл ажиллагааг ТУЗ-ийн даргын зүгээс хангалттай сайн байсан гэж дүгнэж байна. Засаглалын үнэлгээг манай брокер дилерийн компаниуд, хувьцаа авах гэж байгаа хүмүүс их сонирхдог. Итгэл даахуйц компани мөн эсэх дээр энэ мэдээлэл өөрөө чухал байдаг. Тэр үүднээс ТУЗ засаглалын өөрийн үнэлгээг 4 жил тасралтгүй хийж явж байгаа. Өөрөө өөрийгөө үнэлээд байхаар хэмжүүр өсөөд

тогтчих гээд байдаг хандлагатай байдаг учир бид энэ жил хөндлөнгийн оролцоотойгоор үнэлсэн. Үүний үр дүнг та бүхэн харж байвал бид цаашид ажлаа улам сайжруулах өсөж дэвжих боломж нэлээн их байгаа гэж харагдаж байгаа. Яг энэ үнэлгээтэй холбоотойгоор бид ажлаа дараах байдлаар тодорхойлсон. ХЭХ-ийг долоо хоногийн амралтын өдөр зохион байгуулдаг болох. ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, түүнийг тогтмолжуулах. Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулсан байдал, түүний бие даасан, хараат бус байдлыг батлах баримт мэдээллийг ХЭХ-аар хэлэлцэх асуудалд оруулж, мэдээлэл өгдөг болох. Компани дотоод хяналтын 2-р шатны хяналтыг сайжруулах. Олон нийтэд тухай бүр хүргэх мэдээллийн агуулга, цар хүрээг улам бүр сайжруулах. Компанийн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулгыг тасралтгүй сайжруулах. Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг хангах тал дээр тавих хяналтын тогтолцоог боловсронгуй болгох. Анхаарал тавьсан явдалд баярлалаа. Энэхүү мэдээлэл тайлан веб сайт дээр хурлын материал дээр тусгагдсан байгаа учир хангалттай мэдээлэл байгаа гэж бодож байна.

Бид хэлэлцэх асуудлын 6-р хэсэг рүү шилжиж байна. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг та бүхэнд хүргэе.

1. Дамбын Гэрэлмаа

ТУЗ-ийн дарга

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхимийн профессор

2. Банзрагчийн Нандин-Эрдэнэ

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны дарга

СЭЗИС-ийн Бизнесийн Удирдлагын тэнхимийн ахлах багш

3. Мягмарын Баяр

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга

ШУТИС-ийн Үйлдвэрлэл технологийн сургуулийн Хөнгөн Үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын дэд профессор

4. Такэши Камбэ

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн

Asahi Life Insurance ХХК-ийн менежер

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Цагаачийн БААТАРСАЙХАН

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

Таван Богд Группийн Ерөнхийлөгч, Говь ХК-ийн Гүйцэтгэх захирал

2. Дашдаваагийн Хулан

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны гишүүн

Таван Богд Группийн Тэргүүн дэд Ерөнхийлөгч

3. Хидэо Савада

H.I.S компанийн Ерөнхийлөгч

4. Жавзандолгорын Оюунчимэг

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн

Таван Богд Группийн маркетингийн газрын захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧ:

1. Алтангэрэлийн Жаргалмаа нягтлан бодогч мэргэжилтэй, АССА (Эй Си Си Эй)-ийн дэд гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл аудитын хорооны гишүүн

Боловсрол:

2012 Нягтлан бодох бүртгэлийн бакалавр, Оксфорд Брүүксийн их сургууль

2012 АССА Мэргэшлийн түвшний шалгалтууд

2015 Бизнесийн удирдлагын магистр, Санхүү Эдийн Засгийн Их сургууль

2015 Бизнесийн удирдлагын магистр- Глобал менежмент, Хандонг Глобал их сургууль

Хөдөлмөрийн үйл ажиллагаа:

2014 Зөвлөх, Iarudi Consulting ХХК

2013-2014 Нягтлан бодогч, Itezmon ХХК

2015-Одоог хүртэл Нягтлан бодогч, Дүнгээ ХХК

2012-2017 Багш, Санхүү Эдийн Засгийн их сургууль

2016-2018 Нягтлан бодогч, Бурый мэдвэдь ХХК

2017- Одоог хүртэл АССА ахлах багш, хөтөлбөрийн удирдагч GAPE /Global Academy for Professional Education/

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Хэлэлцэх асуудлын дарааллаар одоо асуулт хариултын хэсэг эхлэх гэж байна. Хурал маань өөрөө цахим талбарт шууд дамжуулалт хийгдэж байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд бид бүртгэл хийх

явцдаа та бүхний сонирхсон ялангуяа хувьцаа эзэмшигчдийнхээ сонирхсон асуултуудад бүртгэж авсан. Одоо энэ хэсэгт ирсэн асуултуудыг багцлаад бид бүхэн хариулт өгөхийг хичээж байгаа. Энэ дундуур мөн асуулт орж ирвэл бид хариулахад бэлэн байгаа гэдгийг хэлье. Нөгөө талдаа энэ хугацаанд санал хураах шугам маань нээгдсэн гэдгийг та бүхэнд хүргэхэд таатай байна. Та бүхэн саналаа өгөхөд бэлтгээрэй шугам маань бэлэн байгаа. Сүүлийн 5-6 хоногт нийлээн их асуултууд ирснээс багцлаад асуултын хариултыг манай гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан захирал хариулна.

6. АСУУЛТ ХАРИУЛТ

АСУУЛТ 1

2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр гарсан байна. Үүний үндэслэлийг тайлбарлаж өгнө үү?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Нийт хувьцаа эзэмшигч нартаа баярлалаа. Өнөөдрийн хуралд анхааралд хандуулж, асуулт ирүүлсэн хүмүүст бас талархал илэрхийлье. 2019 онд Говь ХК-ийн борлуулалтын орлого 21 хувиар өссөн хэдий ч 2017 онд түүхий эдийн үнэ 15, 2018 онд 31, 2019 онд 19 хувиар нийт 3 жилийн дотор 65 хувиар өссөнтэй холбоотойгоор компанийн зардал өсөж, 2019 оны цэвэр ашгийн хэмжээ борлуулалтын 1 гаруй хувь буюу 2018 онтой харьцуулахад 86 хувь буурсан нь ногдол ашиг тараах боломжгүй болсон.

АСУУЛТ 2

Гоёо ХХК-г нэгтгэсэнтэй холбоотой мэдээлэл өгнө үү?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Гоёо компанийг 2019 оны 6-р сард 15 сая ам.доллараар худалдаж аваад үүний төлбөрийг 2019 оны 7 сараас 2021 оны 5 сар хүртэл 2 жилийн хугацаанд төлж гүйцэтгэхээр тохиролцоо гэрээ зурсан байгаа. Гоёо ХХК-г худалдаж авснаар компанийн үйлдвэрлэлийн хүчин чадал өсөж, дэлхийн зах зээл дээр Говь ХК-ийн борлуулалтыг өсгөх боломжийг бий болгож байгаа. Мөн дотоодын зах зээл дээр Говь ХК Гоёо ХХК хоорондоо ямарваа нэгэн үр ашиггүй өрсөлдөөнийг зогсоож чадсан гэж хэлж болно.

АСУУЛТ 3

Онлайн борлуулалт ямар явагдаж байгаа талаар мэдээлэл өгнө үү?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: 2019 оны сүүлээс эхлээд Говь ХК онлайн борлуулалтад анхаарлаа хандуулж эхэлсэн. 2018 онд онлайн худалдаа 550 сая төгрөгөөс 4.6 тэрбум төгрөг болж 8,3 дахин өссөн хэдий ч Монголын брэнд ялангуяа Говь-ийн брэндийг дэлхийн зах зээл дээр онлайн худалдаа дээр танилцуулахын тулд маш их зардал гардаг. Энэ зардал хойшдоо ч гэсэн үргэлжлээд явна. Зардал гаргаад брэндээ таниулж мэдүүлсний дараагаар түүний араас борлуулалт өсөөд явна гэж бодож байгаа.

АСУУЛТ 4

Говь ХК ямар стратеги төлөвлөгөө баримтлан ажиллах вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Говь ХК 2019 онд дотоод зах зээл дээр 990,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулсан. Энэ нь нийт Говь ХК-ийн борлуулалтын дотоодын борлуулалт, гадаадын бөөний худалдаа, гадаадын охин компаниар дамжуулсан онлайн худалдаа гэсэн ийм 3 хэсгээс борлуулалт бүрддэг. Энэ жил COVID 19-тэй холбоотойгоор дотоодын борлуулалтыг 30 хувь буурах байх гэж төсөөлж байсан одоогийн байдлаар 50-с дээш хувийн бууралттай явж байгаа. Бөөний худалдаа өнгөрсөн жилийнхээс 30-40 хувийн бууралттай байхаар байгаа. Харин онлайн худалдааг өсгөхийн төлөө манай баг чармайн ажиллаж байгаа. Баярлалаа.

Д.Гэрэлмаа: Говь ХК-ийн хурал шууд дамжуулагдаж байна. Сая бид нэлээн олон асуулт санал авлаа. Энэ асуултад гүйцэтгэх захирал Баатарсайхан хариулна. Та бүхэн санал асуулгадаа идэвхтэй оролцоорой.

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: 4 асуулт ирсэн байна үүнд хариулъя.

АСУУЛТ 5

Ажилчдаа яагаад цомхотгосон бэ? Ахиж цомхотгох уу?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: 1-3 сарын борлуулалтын орлого COVID 19-тэй холбоотойгоор 50 хувиас дээш бууралттай байсан. Ийм учир компани тэсэж үлдэхийн тулд цомхотгохоос өөр аргагүй байдалд орсон. Хойшид цомхотгох эсэхийг COVID 19-ийн нөхцөл байдлаас болно.

АСУУЛТ 6

Түүхий эд хэзээ татаж авч эхлэх вэ? 1 кг түүхий эд хэдээр авах вэ?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Өнөөдөр COVID 19-тэй холбоотойгоор түүхий эдийн үнэ тодорхой болохгүй байгаа. Тодорхой болсон үед нь зах зээлийн үнээр түүхий эдээ худалдаж авна.

АСУУЛТ 7

2019 оны тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулаагүй байгаад тайлбар өгнө үү?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Аудитын тайлан хуулийн хугацаанд гарсан харин жилийн тайлан маш хураангуй хэлбэрээр тусгагдсан байгааг та бүхэн олж уншина уу.

АСУУЛТ 8

Герман улсад хэдэн дэлгүүр нээсэн бэ? Захиалга авах агент ажиллаж байна уу?

Гүйцэтгэх захирал Ц.Баатарсайхан: Германд өөрийн дэлгүүр 2 байсан. Ханбургийн дэлгүүрийг сая 4-р сард хаагаад Берлин хотод нэг дэлгүүртэй болж байгаа. Бодит дэлгүүрээс илүү онлайн дэлгүүртээ ач холбогдол өгч хойшид онлайндаа төвлөрч ажиллана гэж бодож байгаа. Захиалга авах агент бол ажиллахгүй байгаа. Баярлалаа.

6. САНАЛ ХУРААЛТ

Санал өгөх санамжийг видео бичлэгээр танилцуулан санал хураалтыг эхлүүлсэн бөгөөд санал хураалт 15 минут үргэлжлэв.

7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс цахим системээр ирсэн санал хураалтын дүнг нэгтгэв.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Говь ХК-ийн хурал шууд дамжуулалтаар үргэлжилж байгаа. Дэгийн дагуу санал хураалтын хэсэг, асуулт хариултын хэсэг явж өнгөрлөө. Санал хураалтын дүн хэрхэн гарсныг тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулна.

8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Н.Сайнзул: Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал асуулгын тооллогын дүнг танилцуулахад бэлэн болсон. Хуралд ирсэн саналын эрхийн тоо 690,229,900 ширхэг саналын эрх буюу 88.48 хувь байснаас санал ирүүлсэн тоо 689,886,655 ширхэг буюу 99,9 хувьтай. Шуудан брокероор дамжуулан ирүүлсэн санал 689,726,436 буюу 99,9 хувьтай. Онлайнаар ирүүлсэн санал 160,219 буюу 0.023 хувьтай. Хүчингүй санал 1, саналын эрх 6 буюу 0 хувьтай байна. Хэлэлцсэн асуудлын хүрээнд танилцуулахад компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудал дээр зөвшөөрсөн 100 хувь, татгалзсан 0 хувь, түдгэлзсэн 0 хувь байна. Хоёр дахь асуудал буюу компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах асуудал дээр зөвшөөрсөн 97.04 хувь, татгалзсан 0 хувь, түдгэлзсэн 2.96 хувьтай байна. Хэлэлцсэн 3 дугаар асуудал дээр ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай асуудал байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүн Мягмарын Баяр 12.31 хувь, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн Дамбын Гэрэлмаа 12.31 хувь, ТУЗ-ийн хараат бус гишүүн Банзрагчийн Нандин-Эрдэнэ 12.31 хувь, ТУЗ-ийн хараат бус гишүүн Такэши Камбэ 50.76 хувь, ТУЗ-ийн хараат бус гишүүн Алтангэрэлийн Жаргалмаа 12.31 хувьтай байна. ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох тухай асуудал дээр ТУЗ-ийн ердийн гишүүн Цагаачийн Баатарсайхан 15.38 хувь, Хидэо Савада 53.83 хувь, ТУЗ-ийн ердийн гишүүн Жавзандолгорын Оюунчимэг 15.38 хувь, ТУЗ-ийн ердийн гишүүн Дашдаваагийн Хулан 15.38 хувьтай байна. Хэлэлцсэн 3 асуудлыг буюу компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталсан, компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг баталсан, компанийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох асуудлыг баталсан болно.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Н.Сайнзул даргад баярлалаа. Одоо энэ хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулна уу хэмээн нарийн бичгийг дарга Б.Нарантуяа-г урьж байна.

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяа: Говь хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, 2020 оны 4 сарын 24, Дугаар 01, Улаанбаатар хот,

Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.10 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2019 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Хавсралт 1:

ГОВЬ ХК-ИЙН -2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Говь ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2019 оны зорилтуудын талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

Говь ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь тус компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэн баталж, компанийг удирдах үйл ажиллагаандаа Сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгож, Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр зөвлөмж, төлөвлөгөөт зорилтыг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн баталсан 2019 оны бизнес төлөвлөгөө нь компанийн нийт борлуулалтын орлогыг өмнөх оноос 38% өсгөх, бараа материалын үлдэгдлийн удирдлагыг сайжруулж, үлдэгдлийг 40% бууруулах, нийт ажилтны тоог тогтвортой түвшинд байлгаж, чанар болон бүтээмжийг сайжруулахад тусгайлан анхаарах, үйлдвэрлэлийн үйл явцад “Toyota production system”-г нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх, Галлериа Улаанбаатар салбарын борлуулалтыг 2019 онд Үйлдвэрийн дэргэдэх төв дэлгүүрийн борлуулалтын орлогод дүйцэхүйц болгох бодлогыг баримтлахад тус тус чиглэсэн билээ.

Говь ХК 2019 онд 210 тэрбум төгрөгийн борлуулалтыг хийж, бизнес төлөвлөгөөний биелэлт 93 хувь, цэвэр ашиг 2.4 тэрбум төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөө 26 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Гадаад борлуулалт 2019 онд 75 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 101 хувь, дотоод борлуулалт 135 тэрбум төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 90 хувьд хүрчээ.

Мөн тайлант жилд 411 тонн түүхий эд бэлтгэж, нийт 60 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 23 тэрбум төгрөг буюу 38.3% нь тоног төхөөрөмж, барилга байгууламжийн тохижуулалтад зориулсан байна. Тодруулбал 20.9 тэрбум төгрөг буюу 91%-ийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 1.4 тэрбум төгрөг буюу 6,1%-ийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 667 сая төгрөг буюу 2.9%-ийг тавилга, компьютерын тохижуулалтад зарцуулсан байна. Харин нийт хөрөнгө оруулалтын 37 тэрбум буюу 61.6% нь Гоёо ХХК-ийг нэгтгэх хөрөнгө оруулалтад зарцуулагдаж бид үйл ажиллагаагаа амжилттай тэллээ.

Иймд Говь ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг 2019 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай.

Говь хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, 2020 оны 4 сарын 24, Дугаар 02, Улаанбаатар хот, Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийг батлах тухай.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.9.1 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2020 оны 4 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

Хоёр. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороонд хянуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-д даалгасугай.

Гурав. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэл бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

Хавсралт 2:

№	Одоогийн дүрмийн заалт	Шинэчилсэн заалт
	Гурав.Компанийн хувьцаа ба хувь нийлүүлсэн хөрөнгө	

1	3.1 Компанийн зарласан хувьцаа нь нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 780,112,500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 780,112,500 төгрөг байна.	3.1 Компанийн зарласан болон гаргасан хувьцаа нь нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 780,112,500 (долоон зуун наян сая нэг зуун арван хоёр мянга таван зуун) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 780,112,500 төгрөг байна.
Тав. Компани үнэт цаас гаргах, худалдах, эргүүлэн авах		
2	5.3 Хувьцаа нэмж гаргах, хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжи худалдан авах давуу эрх олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэнэ.	Компанийн өрийн хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүнийг тоог Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ. ТУЗ-өөс энэхүү асуудлаар хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулж болно.

3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай.

Говь хувьцаат компани хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоол, 2020 оны 4 сарын 24, Дугаар 02, Улаанбаатар хот, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтууд, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон 2020 оны 4 сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

Хоёр. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Мягмарын БАЯР
Дамбын ГЭРЭЛМАА
Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ
Такэши КАМБЭ
Алтангэрэлийн ЖАРГАЛМАА нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН
Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ
Хидэо САВАДА
Дашдаваагийн ХУЛАН нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Нарантуяадаа баярлалаа. Үүгээр манай хурал өндөрлөж байна. Бид анх удаа цахим хэлбэрээр хурал зохион байгууллаа. Манай Говь ХК-ийн хувьд хувьцаа эзэмшигчдийн хурлыг анх удаа ийм хэлбэрээр явуулж үзлээ. Та бүхний саналыг өргөн татаж оролцуулах, та бүхний сонирхож буй асуултад болж өгвөл хариулт өгөх, амьд хуралтайгаа аль болох ойрхон байлгахыг хичээлээ. Энэ хичээл зүтгэлийн цаана олон хүний хүч хөдөлмөр шингэсэн гэдгийг би зайлшгүй тэмдэглэх шаардлагатай. Хурал зохион байгуулах комиссынхондоо, тооллогын комиссын бүх гишүүддээ, Говь ХК-ийн маркетингийн албаны ажилтнууддаа, ТУЗ-ийн гишүүддээ, мөн энэ талбарыг бидэнд бэлэн болгосон технологийн боломжоор хангаж өгч байгаа бид нартай нягт ажиллагаа хийсэн Livestream компанийн хамт олонд баярлаж буйгаа илэрхийлэн өндрөөс өндөр амжилт хүсье. Цар тахлын үед амаргүй нөхцөл байдалд үйл ажиллагаа явагдаж байгаа. Энэ хүнд хэцүү нөхцөлд манай үйлдвэрийн үйл ажиллагааг сонирхоод, хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье. Та бүхний итгэлийг алдахгүй байхын тулд шинэ ТУЗ-ийн бүрэлдэхүүн хичээл зүтгэл гаргаж ажиллах байх гэж би бодож байна. Нөгөө талдаа та бүхний ажил амьдрал өөдрөг байх болтугай. Төгсгөлд нь нийт Монголын ард түмэнд эрүүл энхийг хүсье. Та бүхэн хувийн сахилга батыг сайн мөрдөж эрүүл энх байгаарай. Баярлалаа та бүхэндээ.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Хурал 11 цаг 40 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга



Д.ГЭРЭЛМАА

Б.НАРАНТУЯА